



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/182

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5, 42 дугаар зүйлийн 42.3, 43 дугаар зүйлийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 14, 18, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Сэлбэ дэд төв" орчмын 158 га талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн нөлөөлөлд өртөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/475 дугаар захирамжаар нөхөн олговроо авч, эзэмшлийн газраа бүрэн чөлөөлсөн иргэн Амарсайханы Пүрэвдоржийн тус дүүргийн 18 дугаар хороо, Яргайт 20 дугаар гудамж, 318д тоот хашааны 1501513814 нэгж талбарын дугаар бүхий газрын газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2011 оны А/90 дүгээр захирамжийн иргэн А.Пүрэвдоржид холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010746